



**ЭРҮҮЛ МЭНДИЙН ХӨГЖЛИЙН
ТӨВИЙН ЗАХИРЛЫН
ТУШААЛ**

2016 оны 03 сарын 22 өдөр

Дугаар A/34

Улаанбаатар хот

Гэрээгээр гүйцэтгэх ажил, албан тушаалын
жагсаалтыг шинэчлэн батлах тухай

Монгол улсын Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1 дэх заалт, Эрүүл мэнд, спортын сайдын 2015 оны “Эрүүл мэндийн хөгжлийн төвийн дүрэм, бүтцийг шинэчлэн батлах тухай” 79 дүгээр тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. Тус төвийн гэрээгээр гүйцэтгэх ажил, албан тушаалын жагсаалтыг хавсралтаар баталсугай.

2. Хавсралтаар батлагдсан ажил, албан тушаалын ажлын байрны тодорхойлолтыг боловсруулан батлуулахыг албадын дарга нарт үүрэг болгосугай.

3. Энэ тушаал гарсантай холбогдуулан төвийн захирлын 2015 оны “Гэрээгээр гүйцэтгэх ажил, албан тушаалын жагсаалт батлах тухай” A/102 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, аж ахуйн албаны дарга (Л.Оюунчимэг)-д даалгасугай.


ЗАХИРАЛ



Ч.БАТ-ЭРДЭНЭ

420122

Эрүүл мэндийн хөгжлийн төвийн захирлын
2016 оны 03 дугаар сарын 22 ны
өдрийн 1/34 дугаар тушаалын хавсралт



Гэрээгээр гүйцэтгэх ажил, албан тушаалын жагсаалт

№	Албан тушаалын нэр	Орон тоо
<i>Судалгаа, төлөвлөлт, статистик мэдээллийн алба</i>		
1	Судалгаа хариуцсан ажилтан	1
2	Оператор	1
	Бүгд	2
<i>Эмнэлгийн мэргэжилтний хөгжлийн алба</i>		
1	Шалгалтын үнэлгээ хариуцсан ажилтан	1
2	Хүний нөөцийн мэдээний сан хариуцсан ажилтан	1
	Бүгд	2
<i>Захиргаа, аж ахуйн алба</i>		
1	Зайн сургалтын медиа орчин хариуцсан ажилтан	2
2	Нийтлэг үйлчилгээ хариуцсан ажилтан	1
3	Тооцооны нягтлан бодогч	1
4	Архивч-номын санч	1
5	Жолооч	1
6	Слесарь	1
7	Үйлчлэгч	2
	Бүгд	9
	Нийт	13